



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 11 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

## НЭРИЙН ДАНСНЫ 2009, 2010 ОНЫ ОРЛОГОД ТООЦОХ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2009 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 29.8 хувиар, 2010 оны хүүгийн хэмжээг 28.3 хувиар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолоор баталсан хүүгийн хэмжээг баримтлан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2009, 2010 оны орлогод хүү тооцох арга хэмжээг 2011 оны 4 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ч.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын алба /Х.Алимаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.НЯМХҮҮ